

2020 ОНЫ 6 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


2020 оны 6 дугаар сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн мэдээг 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ ирүүлсэн. ГССҮТ, УАУТХ эмнэлгүүдээс мэдээ ирээгүй.

Нэг. Амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2020 оны 6 дугаар сард мэдээ ирүүлсэн эрүүл мэндийн байгууллагаар нийт 935 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн байна. 1 ба түүнээс дээш хоногоор хүлээсэн 591 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. Тухайлбал:

УНТЭ 103, УХТЭ 12, УГТЭ 137 , ХСҮТ 339 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна. Харин ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ амбулаторийн хүлээгдэлгүй ажилласан байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ-ийн 2020 оны 6 дугаар сарын амбулаторийн хүлээгдлийг харьцуулсан нь:



Амбулаторийн хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

УНТЭ-ийн 8 кабинетад 103 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 43 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Бөөр судлалын кабинетад 13, зүрх судлалын кабинетад 14, мэдрэл судлалын кабинетад 19, нүд судлалын кабинетад 11, чих, хамар хоолойн кабинетад 1, булчирхай судлалын кабинетад 4, урологийн кабинетад 16, хоол боловсруулах судлалын кабинетад 25 үйлчлүүлэгч тус бүр 2 ба түүнээс хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

УХТЭ-г 5 дугаар сард амбулаторын хүлээгдэл бүртгэгдээгүй байсан бол 6 дугаар сард 2 кабинетад 12 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна Үүнд:

Нүд судлалын кабинетад 10, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны кабинетад 2, үйлчлүүлэгч тус бүр 1 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Өдөртөө 353 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

УГТЭ-ийн 4 кабинетад нийт 137 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сар амбулаторын хүлээгдэл бүртгэгдээгүй байна. Үүнд:

Зүрх судасны кабинетад 51, уушигны кабинетад 21, мэдрэл судлалын кабинетад 30, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны кабинетад 35 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 420 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн 12 кабинетад нийт 339 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 208 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна. Үүнд:

Мэс заслын кабинетад 6, зүрх судасны кабинетад 38, толгой хүзүүний мэс заслын кабинетад 21, туяа эмчилгээний кабинетад 23, химийн кабинетад 57, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний кабинетад 4, цээжний хөндийн мэс заслын кабинетад 58, элэг цөс, нойр булчирхайн кабинетад 53, гепатологийн кабинетад 38, ангиографын кабинетад 22, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетад 19 хүлээгдэл нь 2 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Өдөртөө үйлчлүүлсэн 162 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

Хоёр. Оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2020 оны 6 дугаар сард 582 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлж 400 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд:

УНТЭ 16, УХТЭ 5, УГТЭ 69, СЭМҮТ 84, ХСҮТ 226 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн бол ЭХЭМҮТ оношлогооны хүлээгдэлгүй үйлчилсэн байна.



Оношлогооны хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

УНТЭ-ийн оношлогооны 5 кабинетад 16 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:


Рентген зургийн оношлогооны кабинетад 2, хэвлийн ЭХО-ны кабинетад 8, тархины цахилгаан бичлэгийн кабинетад 2, холтер 1, бүдүүн гэдэсний дурангийн кабинетад 3 үйлчлүүлэгч тус бүр 2-оос дээш хоногийн хугацаатай хүлээгдэл байна.

УХТЭ-т тархины цахилгаан бичлэгийн оношлогооны кабинетад 5 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УГТЭ-ийн 3 кабинетад нийт 69 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: Рентген зургийн кабинетад 12, зүрхний цахилгаан бичлэгийн кабинетад 28, хэвлийн ЭХО-ны кабинетад 29 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын оношлогооны кабинетад 84 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 31 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна.

ХСҮТ-ийн 7 кабинетад 226 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Бүдүүн, шулуун гэдэсний дуран оношлогооны кабинетад 1, компьютер томографийн кабинетад 1, маммографийн кабинетад 5, рентгений кабинетад 67, ходоодны дурангийн кабинетад 29, эхоны кабинетад 88, зүрхний цахилгаан бичлэгийн кабинетад 35 үйлчлүүлэгч тус бүр 2 ба түүнээс дээш хоног хүлээж үйлчлүүлсэн байна.



Дүгнэлт: 2020 оны эхний 6 сарын байдлаар оношлогооны кабинетад огт хүлээгдэлгүй ЭХЭМҮТ ажилласан бол ХСҮТ хамгийн их хүлээгдэлтэй ажиллаж байна. Хамгийн их хүлээгдэл үүсч байгаа оношлогооны тасгаар рентген, хэвлийн ЭХО-ны тасгууд байна.

Гурав. Лабораторийн шинжилгээний хүлээгдэл:


2020 оны 6 дугаар сард мэдээ ирүүлсэн УНТЭ, СЭМҮТ, ЭХЭМҮТ, ХСҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй ажилласан бол 206 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: УХТЭ 43, УГТЭ 163 тус тус үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.



Оношлогооны хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

УХТЭ-ийн тархины цахилгаан бичлэгийн оношлогооны кабинетад 5 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна.


УГТЭ-ийн 3 кабинетад нийт 69 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд: Рентген зургийн кабинетад 12, зүрхний цахилгаан бичлэгийн кабинетад 28, хэвлийн ЭХО-ны кабинетад 29 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.



Дүгнэлт: 2020 оны эхний 6 сарын байдлаар лабораторын кабинетад огт хүлээгдэлгүй ЭХЭМҮТ, ХСҮТ, УНТЭ, СЭМҮТ-үүд ажилласан бол УХТЭ 386 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэй, УГТЭ 314 үйлчлүүлэгч 2 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй ажилласан байна.

Дөрөв. Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2020 оны 6 дугаар сард ЭХЭМҮТ, УНТЭ хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэлгүй ажилласан бол 734 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Үүнд: УХТЭ 67, УГТЭ 365, СЭМҮТ 76, ХСҮТ 226 эмнэлгүүдийн бүртгэн мэдээлснийг нэгтгэн дүгнэв.



Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийг ЭМБ-аар:

УХТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх 5 тасагт нийт 67 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлээс 33 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд: Мэс заслын тасагт 45, бөөр судлалын тасагт 6, зүрх судасны тасагт 7, уушгины тасагт 2, уламжлалт эмчилгээний тасагт 7 үйлчлүүлэгч тус бүр 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна.

УГТЭ-ийн хэвтэн эмчлүүлэх 8 тасгийн нийт 365 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 136 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд:

Бөөр судлалын тасагт 12, зүрх судлалын тасагт 9, уушгины тасагт 7, мэдрэлийн тасагт 15, чих, хамар, хоолойн тасагт 110, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны тасагт 5, мэдрэлийн мэс заслын тасагт 140, зүрхний мэс заслын тасагт 67 үйлчлүүлэгчийн хүлээгдэл тус бүр 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт нийт 76 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 16 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна. Үүнд: 1-3 хоногийн хүлээгдэлтэй 5, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 18, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 25, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 28 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ-д нийт 6 тасагт 226 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 2 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр буурсан байна. Үүнд:

Мэс заслын тасагт 13, элэг, цөс, нойр булчирхайн тасагт 50, химийн тасагт 74, хөнгөвчлөхийн тасагт 31, ангиографийн тасагт 52, дурангийн тасагт 6 үйлчлүүлэгчийн хүлээгдэл 3 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй бүртгэгдсэн байна.

УХТЭ, УГТЭ, СЭМҮТ, ХСҮТ-үүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн 2020 оны 6 дугаар сарын хүлээгдлийг тасгаар харьцуулсан нь:

№	ҮЗЛЭГИЙН КАБИНЕТЫН НЭР	УХТЭ	УГТЭ	СЭМҮТ	ХСҮТ	НИЙТ
1	Бөөр судлалын тасаг	6	12			18
2	Зүрх судасны тасаг	7	9			16
3	Мэс заслын тасаг	45			13	58
4	Мэдрэлийн тасаг		15			15
5	Чих хамар хоолой тасаг	-	110			110
6	Уушгины тасаг	2	7			9
7	Уламжлалт эмчилгээний тасаг	7				7
8	Мэдрэлийн мэс заслын тасаг	-	140			140
9	Зүрхний мэс заслын тасаг		67			67
10	Стрессээс шалтгаалсан сэтгэцийн эмгэг судлалын тасаг	-		76		76
11	Элэг, цөс, нойр булчирхайн тасаг	-			50	50
12	Хими эмчилгээний тасаг	-			74	74
13	Хөнгөвчлөх эмчилгээний тасаг				31	31
14	Ангиографийн тасаг	-			52	52
15	Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг		5			5
16	Дурангийн тасаг				6	6
Нийт хүлээгдэл		67	365	76	226	734

Дүгнэлт: УНТЭ, ЭХЭМҮТ-үүд хэвтүүлэн эмчлэх тасгууд хүлээгдэлгүй ажилласан байна. 6 дугаар сард хамгийн их хүлээгдэл бүртгэгдсэн тасгаар УГТЭ-ийн мэдрэлийн мэс заслын тасаг 140, чих, хамар хоолойн тасагт 110 үйлчлүүлэгчийн хүлээгдэлтэйгээр бүртгэгдсэн байна.

Тав. НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харъяа 5 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Үүнд:

1. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 14, дотрын тасагт 103, ахмадын эмнэлэгт 7 орны хүлээгдэл;
2. Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 16, дотрын тасагт 15;
3. Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 3, дотрын тасагт 38;
4. Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 10, дотрын тасагт 2,
5. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдрэлийн тасагт 7, дотрын тасагт 24, ахмадын эмнэлэгт 40 үйлчлүүлэгчийн хүлээгдэл тус тус хүлээгдэл бүртгэгдсэн байна.


НЭМГ-ын харъяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийг хоногоор харьцуулбал:

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ
			6 сар				
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	14	16	3	10	7
		1-3 хоног	2	10	3	-	-
		3-6 хоног	7	6	-	5	7
		7-14хоног	5	-	-	5	-
		15-30 хоног	-	-	-	-	-
		1 сараас дээш	-	-	-	-	-
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	103	15	38	2	24
		1-3 хоног	-	9	19	-	9
		3-6 хоног	55	6	8	2	13
		7-14хоног	45	-	11	-	2
		15-30 хоног	3	-	-	-	-
		1 сараас дээш	-	-	-	-	-
3	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	7	-	-	-	40
		1-3 хоног	7	-	-	-	-
		3-6 хоног	-	-	-	-	-
		7-14хоног	-	-	-	-	10
		15-30 хоног	-	-	-	-	30
		1 сараас дээш	-	-	-	-	-

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 6 дугаар сард нийт 23833 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх сарын дуудлагаас 2844 дуудлагаар буурсан байна. Нийт дуудлагын 53.6%-ийг 0-20 минутад, 31 %-ийг 21-40 минутад, 11 %-ийг 41-60 минутад, 4.2 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

**Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний
2020 оны эхний 6 сарын хүлээгдлийн мэдээ**

№	Үзүүлэлт	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	
		Дуудлагын тоо	Дуудлагын тоо	Дуудлагын тоо	Дуудлагын тоо	Дуудлагын тоо	Дуудлагын тоо	
1	Нийт дуудлага	39812	27322	21010	20433	26677	23833	
2	Хүлээгдлийн үйлчилгээний үнэмлэхүй үнэ	0-20 минут	13282	12015	9776	11425	15525	12773
3		21-40 минут	11868	9956	6907	6112	7049	7387
4		41-60 минут	6999	4120	2814	2080	2958	2668
5		1 цагаас дээш	7663	1231	1513	816	1145	1005



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА**